

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

БАТЛАВ:

“АЛТАЙН ХҮДЭР” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

В.ЦЫТОВБАЯР

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

(Гэрээний дугаар: 145/19)

2014 оны 5 сарын 19-ний өдөр
Алтай хот

Энэхүү Хамтран Ажиллах Гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Нэг талаас Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар (цаашид “А” тал гэх), нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот-13, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж-8 хаягт байрлах Регистрийн 5095549, Улсын бүртгэлийн 9019032110 дугаартай “Алтайн хүдэр” ХХК (цаашид “Б” тал, хамтад нь “Талууд” гэнэ) нар Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн, хоорондын зөвшилцөл, харилцан ойлголцлыг баталгаажуулан 2014 оны 5 дугаар сарын 19-ний өдөр дор дурьдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Б тал орон нутагт тулгамдаад байгаа энэхүү Гэрээнд тусгагдсан асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллах болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд А тал зохих үйл ажиллагааг зохион байгуулж, Б талын бизнесийн үйл ажиллагааг дэмжих, Талуудын хооронд байгуулсан холбогдох бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.

ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 2.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Гэрээг удирдлага болгоно.
- 2.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ил тод, шударга, нээлттэй ажиллах зарчмыг баримталж, үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.
- 2.3. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ бие биенээ харилцан хүндэтгэх болон албаны ёс зүй, зохистой харилцааг эрхэмлэн хамтарч ажиллана.
- 2.4. Энэхүү Гэрээтэй холбоотой Гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ холбогдох гэрээ хэлцлийг Талууд тухай бүр байгуулан хамтран ажиллах ба тэдгээр гэрээ хэлцэл нь энэхүү Гэрээний бүрэлдэхүүн хэсэг буюу салшгүй хэсэг байна.
- 2.5. Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ нөгөө талын зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй бөгөөд хэрэв шилжүүлэхээр бол заавал нөгөө талаас бичгээр зөвшөөрөл авсан байна. Уг заалт нь Б тал Гэрээнд заасан үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор бусад гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийг томилон ажиллуулахад хамаарахгүй.
- 2.6. Энэхүү гэрээгээр талуудын хооронд хамтран шийдвэрлэхээр тохиролцсон санхүүжилттай холбоотой асуудлыг талуудын тохиролцсоны дагуу “Шинэ Эрин Хөгжил Сан” ТББайгууллага гүйцэтгэгчийн үүрэг хүлээж хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Талууд дараах арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

3.1.1. Уурхайгаас Бургастай боомт хүртлэх 168.3км хатуу хучилттай автозамыг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2014-2015 онд барьж байгуулна. /2014 онд 84 км, 2015 онд 85,1 км замыг ашиглалтад оруулна/